



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/032/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>  Улаанбаатар хот 2025 он	Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч: Я.Самбууням Утас:261585 Цахим хаяг: <a href="mailto:sambuunyamy@audit.gov.mn">sambuunyamy@audit.gov.mn</a>  Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: <a href="mailto:naranchimegts@audit.gov.mn">naranchimegts@audit.gov.mn</a>  Аудитын менежер: С.Нацагдорж Утас: 260512 Цахим хаяг: <a href="mailto:natsagdorjs@audit.gov.mn">natsagdorjs@audit.gov.mn</a>  Ахлах аудитор: Ц.Батсүх Утас: 261729 Цахим хаяг: <a href="mailto:batsukhts@audit.gov.mn">batsukhts@audit.gov.mn</a>  Аудитор: Б.Батхишиг Утас: 261729 Цахим хаяг: <a href="mailto:batkhisigb@audit.gov.mn">batkhisigb@audit.gov.mn</a>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2025.04.25 № 1600  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн нэгтгэсэн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Монгол Улсын дээд шүүх нь Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн 227.0 сая төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн шүүгчийн сургалтын цахим платформыг 2024 оны 8 дугаар сард хүлээн авсан. Уг систем нь орон нутгийн болон ачаалал ихтэй шүүгчдийн сургалтын хүртээмжийг нэмэгдүүлэх, сургалтын бүртгэл болон багц цагийн тооцооллыг автоматжуулах, Шүүхийн академийн хүний нөөцийн ачааллыг бууруулах, сургалтын нэгдсэн удирдлагын тогтолцоог бүрдүүлэхэд хувь нэмэр оруулсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 566 дугаар тогтоолоор 13,430.8 сая төгрөгийн өртөгтэй 10582 м.кв талбай бүхий Хангарди ордны барилга, 19.1 сая төгрөгийн газар эзэмших эрхийн хамт Нийслэлийн өмчөөс Монгол Улсын дээд шүүхэд ажлын байрны зориулалтаар шилжүүлсэн байна.

Хангарди ордны их засварт 11,528.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 10,969.9 сая төгрөгийн хөрөнгийн санхүүжилт авч, 1,969.3 сая төгрөгийг их засварын ажилд, 975.2 сая төгрөгийг тоног төхөөрөмж худалдан авахад зарцуулж, 8,025.4 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

Тус ордныг ажлын байрны зориулалтаар тохижуулах ажлын хүрээнд хөрөнгийн болон урсгал зардлын санхүүжилтийн эх үүсвэрээр нийт 1,785.0 сая төгрөгийн 93 нэр төрлийн 402 ширхэг тавилга, тоног төхөөрөмжийг худалдан авсан байна.

### **Бусад асуудал**

Тайлант онд Монгол Улсын шүүхийн тухай хуульд зааснаар шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах ажлын хүрээнд анхан, давж заалдах шатны шүүх болон авлигын гэмт хэргийн шүүх хуралдааныг нээлттэй хийж, албан ёсны вэбсайтаар шууд дамжуулж байна.

Тайлант онд нийт 3,101 хэрэг бүртгэгдсэнээс 50.7 хувь нь иргэний, 32.3 хувь нь эрүүгийн, 16.8 хувь нь захиргааны, 0.2 хувь нь сахилгын хэрэг эзэлж байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2024 онд хэрэгжүүлэх “Хяналтын дээд шатны шүүн таслах ажиллагаа” хөтөлбөрийн хүрээнд хяналтын шатны журмаар хуулийн хугацаанд хянан шийдвэрлэсэн хэрэгжилтийг 93.0 хувьд хүргэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 94.0 хувьтай байна.

### **Санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд Аудитын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains Mongolian text and a central emblem. To the right of the stamp, the name 'Д.ЗАГДЖАВ' is printed in red capital letters.

Д.ЗАГДЖАВ

## 2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>710,387.7</b>	<b>18,587,163.8</b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>120,120.0</b>	<b>8,099,819.7</b>
33	<b>АВЛАГА</b>	<b>12,825.0</b>	<b>188.8</b>
34	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>69,466.1</b>	<b>2,057,174.1</b>
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>507,976.5</b>	<b>489,385.5</b>
36	<b>БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>	<b>-</b>	<b>7,940,595.7</b>
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6,207,285.7</b>	<b>20,155,985.2</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>6,207,285.7</b>	<b>20,155,985.2</b>
39200	Биет хөрөнгө	5,783,236.0	19,413,704.6
39300	Биет бус хөрөнгө	424,049.6	742,280.6
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>6,917,673.3</b>	<b>38,743,149.0</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>12,825.0</b>	<b>8,025,396.5</b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>12,825.0</b>	<b>8,025,396.5</b>
41300	Өглөг	12,825.0	8,025,396.5
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>6,904,848.3</b>	<b>30,717,752.5</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>6,904,848.3</b>	<b>30,717,752.5</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,428,220.1	1,428,220.1
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	1,428,220.1	1,428,220.1
51200	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>3,824,800.0</b>	<b>27,731,688.0</b>
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,651,828.2	1,557,844.3
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>6,917,673.3</b>	<b>38,743,149.0</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>10,967,700.5</b>	<b>41,461,283.6</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,562.6</b>	<b>13,219,585.3</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,562.6</b>	<b>12,992,545.3</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>-</b>	<b>198,803.3</b>
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	198,803.3
120009	Бусад орлого	1,282.6	1,257.0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	12,764,601.7

Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	280.0	27,883.3
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	-	<b>227,040.0</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>10,966,137.9</b>	<b>28,241,698.4</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>10,914,755.6</b>	<b>28,177,123.4</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	10,914,755.6	17,207,209.6
131005	Хөрөнгийн санхүүжилт	-	10,969,913.8
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>51,382.3</b>	<b>64,575.0</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	51,382.3	64,575.0
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>11,365,561.6</b>	<b>17,635,888.6</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>11,365,561.6</b>	<b>17,635,888.6</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>10,314,539.9</b>	<b>16,060,428.1</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,773,493.7	10,775,715.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	847,715.0	1,348,934.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	189,259.1	264,950.7
2104	Хангамж, бараа материалын зардал	410,258.8	709,798.5
2105	Нормативт зардал	50.0	10,580.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	162,188.5	210,073.2
2107	Томилолт, зочны зардал	204,721.2	492,841.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	369,443.9	265,577.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,357,409.8	1,981,955.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,051,021.7	1,575,460.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	170,325.0	658,826.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	880,696.7	916,634.6
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>(397,861.2)</b>	<b>23,825,395.0</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	32,790.8
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>(397,861.2)</b>	<b>23,792,604.2</b>

**2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,302,709.5	7,302,709.5

Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,302,709.5	7,302,709.5
9	Тайлант үеийн үр дүн	(397,861.2)	(397,861.2)
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,904,848.3	6,904,848.3
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	114,283.8	114,283.8
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,019,132.1	7,019,132.1
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(93,983.8)	(93,983.8)
19	Тайлант үеийн үр дүн	23,792,604.2	23,792,604.2
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	30,717,752.5	30,717,752.5

#### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	10,980,245.5	36,268,351.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14,107.6	8,026,653.5
120	Нийтлэг татварын бус орлого	14,107.6	8,026,653.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,966,137.9	28,241,698.4
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	10,914,755.6	28,177,123.4
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	51,382.3	64,575.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,656,466.1	16,614,059.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,656,466.1	16,614,059.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,592,619.3	15,038,598.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,773,493.7	10,775,034.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	847,715.0	1,348,934.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	189,259.1	299,513.4
2104	Хангамж, бараа материалын зардал	445,681.2	507,929.9
2105	Нормативт зардал	4,824.0	10,580.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	160,817.1	233,595.3
2107	Томилот, зочны зардал	204,721.2	527,899.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	451,441.5	328,847.4

Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	514,666.5	1,006,263.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,063,846.7	1,575,460.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	170,325.0	658,826.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	893,521.7	916,634.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	323,779.4	19,654,292.5
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	364,659.4	11,674,592.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	364,659.4	11,674,592.8
2200	Дотоод эх үүсвэрээр	364,659.4	11,674,592.8
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(364,659.4)	(11,674,592.8)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(40,880.0)	7,979,699.7
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	161,000.0	120,120.0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	120,120.0	8,099,819.7

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	29,070,080,500.00	27,274,119,409.08	1,795,961,090.92	93.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	17,541,280,500.00	16,304,205,603.69	1,237,074,896.31	92.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭ ЭНИЙ ЗАРДАЛ	16,602,150,600.00	15,685,208,827.13	916,941,772.87	94.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	11,224,613,500.00	10,775,034,861.41	449,578,638.59	96.0
210101	Үндсэн цалин	6,846,500,900.00	6,587,284,664.94	259,216,235.06	96.2
210102	Нэмэгдэл	2,305,187,100.00	2,087,524,656.95	217,662,443.05	90.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,314,088,700.00	1,198,615,412.44	115,473,287.56	91.2
210104	Урамшуулал	758,836,800.00	901,610,127.08	(142,773,327.08)	118.8
2102	Ажил олгогчоос нийгмийн	1,426,076,600.00	1,348,934,704.98	77,141,895.02	94.6

Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

	<b>даатгалд төлөх шимтгэл</b>				
210201	Тэтгэврийн даатгал	969,732,200.00	918,213,038.71	51,519,161.29	94.7
210202	Тэтгэмжийн даатгал	114,086,100.00	107,767,454.43	6,318,645.57	94.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	57,043,000.00	53,988,426.45	3,054,573.55	94.6
210204	Ажилгүйдлийн даатгал	57,043,100.00	53,666,305.28	3,376,794.72	94.1
210205	Эрүүл мэндийн даатгал	228,172,200.00	215,299,480.11	12,872,719.89	94.4
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>454,993,900.00</b>	<b>247,317,620.35</b>	<b>207,676,279.65</b>	<b>54.4</b>
210301	Гэрэл, цахилгаан	186,801,600.00	69,393,800.08	117,407,799.92	37.1
210302	Түлш, халаалт	86,796,300.00	41,090,025.27	45,706,274.73	47.3
210303	Цэвэр, бохир ус	50,428,400.00	11,115,395.00	39,313,005.00	22.0
210304	Байрны түрээс	130,967,600.00	125,718,400.00	5,249,200.00	96.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>551,172,500.00</b>	<b>507,929,911.58</b>	<b>43,242,588.42</b>	<b>92.2</b>
210401	Бичиг хэрэг	145,955,000.00	123,337,480.50	22,617,519.50	84.5
210402	Тээвэр, шатахуун	63,292,500.00	62,623,500.00	669,000.00	98.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	87,203,800.00	76,417,430.08	10,786,369.92	87.6
210404	Ном, хэвлэл	45,737,600.00	48,236,489.00	(2,498,889.00)	105.5
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	20,836,400.00	19,223,100.00	1,613,300.00	92.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	188,147,200.00	178,091,912.00	10,055,288.00	94.7
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>10,938,200.00</b>	<b>10,580,000.00</b>	<b>358,200.00</b>	<b>96.7</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,938,200.00	10,580,000.00	358,200.00	96.7

Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>836,074,000.00</b>	<b>816,099,592.94</b>	<b>19,974,407.06</b>	<b>97.6</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	511,063,400.00	500,639,846.00	10,423,554.00	98.0
210602	Тавилга	113,479,000.00	107,315,100.00	6,163,900.00	94.6
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	8,064,900.00	8,363,000.00	(298,100.00)	103.7
210604	Урсгал засвар	203,466,700.00	199,781,646.94	3,685,053.06	98.2
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>552,716,600.00</b>	<b>527,899,555.73</b>	<b>24,817,044.27</b>	<b>95.5</b>
210701	Гадаад албан томилолт	447,568,400.00	439,415,415.73	8,152,984.27	98.2
210702	Дотоод албан томилолт	63,672,500.00	53,006,380.00	10,666,120.00	83.2
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	41,475,700.00	35,477,760.00	5,997,940.00	85.5
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>484,650,400.00</b>	<b>425,248,972.82</b>	<b>59,401,427.18</b>	<b>87.7</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	165,447,000.00	135,505,190.50	29,941,809.50	81.9
210803	Даатгалын үйлчилгээ	66,194,000.00	60,585,000.00	5,609,000.00	91.5
210804	Тээврийн хэрэгслийн татвар	3,553,000.00	2,650,549.00	902,451.00	74.6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	226,623,200.00	218,925,637.32	7,697,562.68	96.6
210807	Газрын төлбөр	22,833,200.00	7,582,596.00	15,250,604.00	33.2
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,060,914,900.00</b>	<b>1,026,163,607.32</b>	<b>34,751,292.68</b>	<b>96.7</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,692,600.00	11,888,600.00	22,804,000.00	34.3

Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210902	Хичээл үйлдвэрлэл ийн дадлага хийх	1,026,222,300.00	1,014,275,007.32	11,947,292.68	98.8
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>939,129,900.00</b>	<b>618,996,776.56</b>	<b>320,133,123.44</b>	<b>65.9</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>939,129,900.00</b>	<b>618,996,776.56</b>	<b>320,133,123.44</b>	<b>65.9</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	617,691,800.00	302,503,966.56	315,187,833.44	49.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	321,438,100.00	316,492,810.00	4,945,290.00	98.5
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>11,528,800,000.00</b>	<b>10,969,913,805.39</b>	<b>558,886,194.61</b>	<b>95.2</b>
221001	Их засвар	8,227,400,000.00	7,781,998,854.00	445,401,146.00	94.6
222001	Тоног төхөөрөмж	3,301,400,000.00	3,187,914,951.39	113,485,048.61	96.6
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮ ЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>29,070,080,500.00</b>	<b>27,274,119,409.09</b>	<b>1,795,961,090.92</b>	<b>93.8</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>29,070,080,500.00</b>	<b>27,274,119,409.08</b>	<b>1,795,961,090.92</b>	<b>93.8</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	29,070,080,500.00	27,274,119,409.08	1,795,961,090.92	93.8
	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	17,541,280,500.00	16,304,205,603.69	1,237,074,896.31	92.9
	Хөрөнгийн санхүүжилт	11,528,800,000.00	10,969,913,805.39	558,886,194.61	95.2
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	161,000,000.00	120,120,000.00	(40,880,000.00)	74.6
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	120,120,000.00	8,099,819,672.90	7,979,699,672.90	6,743.1
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИ</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

	<b>ЙН АНГИЛАЛ</b>				
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛ АГЫН ТОО</b>	<b>2</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>100.0</b>
610001	Төсвийн байгууллага	2	2	-	100.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГС АДЫН ТОО</b>	<b>263</b>	<b>223</b>	<b>40</b>	<b>84.8</b>
620001	Удирдах ажилтан	11	11	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	212	172	40	81.1
620003	Үйлчлэх ажилтан	40	40	-	100.0
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>263</b>	<b>223</b>	<b>40</b>	<b>84.8</b>
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	136	70	66	51.5
650005	ШУ-ны салбарын төрийн үйлчилгээни й албан хаагч (ТҮШУ)	56	64	(8)	114.3
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээни й албан хаагч (ТҮЭМ)	2	-	2	-
650009	Төрийн үйлчилгээни й бусад албан хаагч (ТҮ)	43	67	(24)	155.8
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	1	-	1	-
650012	Шүүгч, прокурор	25	22	3	88.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>64,574,952.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>64,574,952.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	<b>52,195,800.00</b>
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	-	<b>52,195,800.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	-	26,000,000.00
210302	Түлш, халаалт	-	15,422,389.00
210303	Цэвэр, бохир ус	-	3,743,866.00
210304	Байрны түрээс	-	7,029,545.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	<b>12,379,152.00</b>
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	<b>12,379,152.00</b>
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжил төвлөрүүлэх шилжүүлэг	-	12,379,152.00
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>64,574,952.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	<b>64,574,952.00</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	64,574,952.00
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	-	<b>-</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 11,620.4 сая төгрөгийн 2 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

Аудитаар нийт 18.2 сая төгрөгийн 7 зөрчил илэрснээс, 1.9 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 16.3 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 4 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 18.2 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшин 170.5 сая төгрөгөөс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

#### 3.1 Харьяа байгууллагууд

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэснээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 1 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан. Аудитад хамрагдсан 1 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 18.2 сая төгрөгийн 6 зөрчил илэрснээс, 1.9 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 16.3 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 3 зөвлөмж өгсөн.

#### 3.2 Төсвийн ерөнхийлөн захирагч

Аудитаар харьяа байгууллагуудад тавих дотоод хяналтыг сайжруулах зөвлөмж өгсөн.

##### 3.2.1 Зөвлөмж

1. Харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт сул байгаагаас санхүүгийн тайлангийн аудитаар нийт санхүүгийн 18.2 сая төгрөгийн, нийцлийн 8.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 14 дүгээр зүйлийн 14.2 "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 14.2.5 "өөрийн агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах", 14.2.10 "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 69 дүгээр зүйлийн 69.1 "Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудад тавих дотоод хяналтыг сайжруулан зөрчлийг давтан гаргахгүй ажиллах.

#### 3.3 Түүвэрт хамрагдсан байгууллага

##### 3.3.1 Төлбөрийн акт

1.Илрүүлэлт: Шүүхийн академи нь гадаад албан томилолтоор ажилласан хугацаанд 1.1 сая төгрөгийн хоол, унааны мөнгийг давхардуулан олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.3 "үр ашигтай байх", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2 "Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх

төлбөр дараах зардлаас бүрдэнэ: 2.2.1. унааны зардал; 2.2.2. байрны зардал; 2.2.3. хоолны зардал" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гадаад албан томилолтоор ажилласан хугацаанд хоол, унааны мөнгийг давхардуулан олгосон зөрчлийг арилгаж, нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох;

2.Илрүүлэлт: Шүүхийн академи нь сургалтын хөтөлбөрийн орон тооны бус хорооны бүрэлдэхүүнд байдаггүй 2 ажилтанд 0.8 сая төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 "Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглоно", "Шүүхийн академийн сургалтын хөтөлбөрийн орон тооны бус хорооны ажиллах журам"-ын 6 дугаар зүйлийн 6.1 "хороо орон тооны бус 15 гишүүнтэй байна. Үүнд: 6.1.1 шүүхийн академийн захирал, 6.1.2 хяналтын шатны шүүхийн эрүү, иргэн, захиргааны хэргийн танхимын тус бүр нэг шүүгч, 6.1.3 эрүү, иргэн, захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн тус бүр нэг шүүгч, 6.1.4 эрүү, иргэн, захиргааны хэргийн анхан шатны шүүхийн тус бүр нэг шүүгч, 6.1.5 шүүхийн ерөнхий зөвлөлийн нэг төлөөлөл, 6.1.6 шүүхийн сахилгын хорооны нэг төлөөлөл, 6.1.7 хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нэг төлөөлөл, 6.1.8 хууль, их дээд сургууль болон эрдэмтэн судлаачийн 2 төлөөлөл" гэж тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шүүхийн академи нь сургалтын хөтөлбөрийн орон тооны бус хорооны бүрэлдэхүүнд байдаггүй 2 ажилтанд урамшуулал олгосон зөрчлийг арилгаж, нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

### **3.3.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Шүүхийн академи нь ажилтан, албан хаагчдын ашиглаж буй эд хөрөнгийг дахин давтагдашгүй кодоор бүртгэлжүүлж, хяналт тавьж ажиллаагүй бөгөөд өмчийн хадгалалт, хамгаалалт, хяналтын зохион байгуулалт хангалтгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай 67 дугаар зүйлийн 67.1 "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", 67.2 "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажилтан, албан хаагчдын ашиглаж буй эд хөрөнгийг бүрэн коджуулж, хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 267 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

*Харьяа байгууллага*

Аудитын илрүүлэлт:

Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын нийт 456.6 сая төгрөгийн 4 гүйлгээ, зарлагын нийт 3,074.5 сая төгрөгийн 9 гүйлгээг шилэн дансанд хугацаа хоцроож мэдээлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

##### 4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

*Түүвэрт хамрагдсан байгууллага*

Илрүүлэлт: Шүүхийн академийн төсөвт туссан арга хэмжээ тус бүрээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг төлөвлөж батлаагүй, төлөвлөгөөнд тусгагдаагүй 8.4 сая төгрөгийн контейнер худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 “Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална”, 44.2 “Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд ерөнхий гэрээний аргаар худалдан авах бараа, үйлчилгээг тусгасан байна” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт туссан арга хэмжээ тус бүрээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг төлөвлөж батлаагүй, төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө худалдан авсан зөрчлийг таслан зогсоож, цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт: Шүүхийн академийн цагийн бүртгэлийн ситемээс мэдээлэл дутуу татагдсан шалтгаанаар зарим ажилтны цаг бүртгэлийг анхан шатны баримтанд хавсаргаж, архивлаагүй орхигдуулсан байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.5 "Ажил олгогч ажилтны ажлын цагийн бүртгэлийг хөтлөх үүрэгтэй", 107 дугаар зүйлийн 107.1."Ажил олгогч хуульд өөрөөр заагаагүй бол үндсэн цалинг ажлын байрны шинжилгээ, үнэлгээ, эсхүл ажилтны ур чадварт үндэслэн цагаар, хийснээр, бусад хэлбэрээр тооцно" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах

зарчмыг баримтална" 5.1.4 "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6 "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилтан, албан хаагчдын цаг бүртгэлд тавих хяналтыг сайжруулах зөвлөмж өгсөн.

## 5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Улсын дээд шүүхийн Тамгын газар	2	11,620.4	2	11,620.4	-	-	2	11,620.4	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>11,620.4</b>	<b>2</b>	<b>11,620.4</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>11,620.4</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч	1	-	-	-	-	-	1	-
Улсын дээд шүүхийн Тамгын газар	3	16.3	-	-	1	16.3	2	-
Шүүхийн академи	3	1.9	2	1.9	-	-	1	-
<b>Дүн</b>	<b>7</b>	<b>18.2</b>	<b>2</b>	<b>1.9</b>	<b>1</b>	<b>16.3</b>	<b>4</b>	<b>-</b>

Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>						
Улсын дээд шүүхийн Тамгын газар	1	-	-	-	1	-
<b>Бусад хууль тогтоомжийн зөрчил</b>						
Шүүхийн академи	2	8.4	1	8.4	1	-
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>8.4</b>	<b>1</b>	<b>8.4</b>	<b>2</b>	<b>-</b>